



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/128

Хэрлэн сум

Монгол цэргийн өдрийг тэмдэглэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 101 жилийн ойн хүрээнд Батлан хамгаалах бодлого зорилт, Зэвсэгт хүчнийг орон нутаг, ард иргэдэд сурталчлах, цэрэг иргэний холбоог бэхжүүлэх зорилгоор “Монгол цэргийн өдөр”-ийг 2022 оны 3 дугаар сарын 12-ны өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 16-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2. “Монгол цэргийн өдөр”-ийн арга хэмжээг зохион байгуулах комиссыг 1 дүгээр, хөтөлбөрийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. “Монгол цэргийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх тусгай төлөвлөгөө гаргаж хөтөлбөрт заагдсан арга хэмжээнүүдийг зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг зохион байгуулах комисст, арга хэмжээнд зохион байгуулалттай оролцохыг “Чингис” цэргийн хүрээний анги, байгууллагууд болон цэрэгжсэн байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




Ц.ЧОГСОМЖАВ

• 231010345

Аймгийн Засаг даргын 2022 оны
А/28 03 дугаар сарын 10 өдрийн
захирамжийн нэгдүгээр хавсралт

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 101 ЖИЛИЙН ОЙ,
“МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР”-ИЙН АРГА ХЭМЖЭЭГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Комиссын дарга:	Ж.Ганбаатар	Засаг даргын Тамгын газрын дарга
Орлогч дарга:	Н.Хүрэлээ	Цэргийн штабын дарга, Хурандаа
Гишүүд :	Н.Мягмарцоож	Зэвсэгт хүчний 232-р ангийн захирагч, Хурандаа
	П.Мөнхбаатар	Хилийн 0287 дугаар ангийн захирагч, Хурандаа
	Ж.Эрдэнэбат	Онцгой байдлын газрын дарга, Хурандаа
	Д.Батхүү	Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн хурандаа
	Д.Хатанбаатар	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-419 дүгээр нээлттэй хорих ангийн дарга, Хурандаа
	Ц.Батсайхан	Монгол цэргийн нэгдсэн холбооны Хэнтий аймаг дахь салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга
	А.Сарантуяа	Батлах хамгаалах, туслах нийгэмлэгийн Хэнтий аймгийн зөвлөлийн дарга
Нарийн бичгийн дарга:	С.Галбадрах	Цэргийн штабын орон нутгийн хамгаалалт, сургалтын офицер, Хошууч



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 101 ЖИЛИЙН ОЙ,
“МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР”-ИЙН АРГА
ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

- 3 дугаар сарын 12-ны Бямба гариг
- 09.00 Пауэрлифтингийн тэмцээн Засаг даргын Тамгын газар,
Цэргийн штаб
- 3 дугаар сарын 15-ны Мягмар гариг
- 12.00 Партизан Б.Пунцагийн хөшөөнд
цэцэг өргөх Зохион байгуулах комисс
- 13.00 Аймгийн Засаг дарга анги, байгууллагын
дарга нартай уулзалт хийх Зохион байгуулах комисс
- 3 дугаар сарын 16-ны Мягмар гариг
- 09.00 Буудлагын тэмцээн Хилийн 0287 дугаар анги
- 09:00 Сүхбаатарын одонт хурандаа
Ш.Дорж агсаны нэрэмжит “Цэрэг эрс-2022”
Марш тактикийн аварга тасаг шалгаруулах
тэмцээн Зэвсэгт хүчний 232 дугаар анги
- 18.00 Дүн гаргаж, шагнал гардуулах Зохион байгуулах комисс